



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



# ТҮҮХ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

- 1911 онд Монголчууд аль улсын эрхшээлээс гарч, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан бэ?  
A. Манж Го улс      B. Хятад улс      C. Дундад иргэн улс      D. Манж Чин улс
- Доорх түүхэн зүтгэлтнүүдээс хэн нь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын нэг вэ?  
A. Д.Сүхбаатар      B. Т.Намнансүрэн      C. Д.Бодоо      D. Х.Чойбалсан
- “1911 оны 12-р сарын 29-ний өдрийн яг ёслол болсон цаг мөчид, Монголын өнцөг булан бүрд хүмүүс Хүрээний зүг хандаж, нэгэн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясжээ. Үүнийг үзсэн гадаадынхан олон Монголчуудын нүд урьд өмнө хэзээ ч ингэж гэрэлтэж байсныг хараагүй” хэмээн бичсэн байдаг. Дээрх түүхэн үйл явдал ямар утга санаа илэрхийлж байна вэ?  
A. Өв уламжлал, шашнаа дээдлэх зан үйл, үйл хэрэг  
B. Ёс заншил, өв уламжлалаа хүндэтгэх ёсыг бэхжүүлэх үйл хэрэг  
C. Шашин шүтлэг, өв соёлоо хүндэтгэх үйл хэрэг  
D. Үндэсний сэргэн мандалтын бодит үр дүн, үйл хэрэг
- БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн агуулгад аль нь хамаарах вэ?  
A. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилт дэвшүүлэх  
B. Монгол улсад улсын, хувийн, хоршооны өмчийн хэлбэрүүдийг зөвшөөрөх  
C. МАХН бол төр нийгмийн удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин болохыг заах  
D. Монгол улсын иргэд угсаа, шашин, эрэгтэй эмэгтэй ялгаваргүй тэгш эрхтэйг тунхаглах
- Улс орноо хөгжүүлэхэд “Үндэсний ардчилсан” чиг шугам баримталж байсан улс төрийн зүтгэлтнүүдийг хэрхэн нэрлэж байсан бэ?  
A. Шашныхан      B. Зүүнтэн      C. Баруунтан      D. Большевикууд
- Цэгийн оронд тохирохыг сонгоно уу.  
Зөвлөлтийн удирдагчид Монголд буруу бодлого тулган хэрэгжүүлснээ ухаарч, 1932 оны зунаас ..... хэрэгжүүлсэн юм.  
A. Шинэ засгийн бодлого      B. Шинэ эргэлтийн бодлого  
C. Шинэ сэргэлтийн бодлого      D. Шинэ зууны бодлого


- Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.




- Шинэ эргэлтийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого
- Аж ахуй соёлоо хөгжүүлэх III таван жилийн төлөвлөгөө
- Атарын 1-р аян, Атарын 2-р аян эхлэв.
- Малчдыг нэгдэлжүүлэх болов, 1-р цахилгаан станцыг байгуулав.

8. Дараах баримтыг анхааралтай уншаад, асуултад хариулна уу.  
“Монгол Улсыг үүнээс хойш Бүрэн эрхтэй ард улс гэж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг УИХ ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газар гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүслэн дагавал зохино” гэсэн баримт юуг илэрхийлж байна вэ?  
A. Төрийн дээд эрхийг ноёд эдлэх болсон тухай өгүүлжээ.  
B. Монгол Улс бүгд найрамдах засаглалтай болсон тухай өгүүлжээ.  
C. Төрийн дээд эрхийг Засгийн газар барих болсон тухай өгүүлжээ.  
D. Монгол улс Засгийн газартай болох тухай өгүүлжээ.
9. Өрнө дахины тэргүүний хөгжилтэй улсуудад үндэсний боловсон хүчнийг бэлтгэх зорилтын хүрээнд суралцагсдыг 1929 онд яагаад эргүүлэн татсан бэ?  
A. ЗОУ-ын тулгалт шахалт, зүүнтний алдаатай бодлогын уршгаар  
B. Богд хааны тушаалаар шашны сургууль бэлтгэх болсон учраас  
C. Манж Чин улсын хааны тушаалаар, цэрэгт татах зорилгоор  
D. Дундад Иргэн улсын тулгалт шахалтаас
10. 1969 онд хүн амын бүртгэлийн мэдээгээр нийт хүн амын 82,4% нь, үүнээс эмэгтэйчүүдийн 76,6% нь ямар бичигтэн болсон бэ?  
A. Монгол бичигтэн      B. Тод бичигтэн      C. Латин бичигтэн      D. Кирилл бичигтэн
11. 1921 онд Дотоод яамны бүтцэд сургууль хариуцсан хэлтэс байв. Харин 1924 онд энэ нь ямар нэртэй яам болж өөрчлөгдсөн бэ?  
A. Сургууль боловсрол хариуцсан яам      B. Боловсрол, Шинжлэх ухааны яам  
C. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яам      D. Боловсролын сургууль
12. Эрүүлийг хамгаалахтай холбоо бүхий баримтыг сонгоорой.  
A. 1986 онд бүх аймаг нэгдэл дундын рашаан сувиллын газартай болов.  
B. 1973 онд тэтгэврийн хуулиуд гарч, даатгалд бүх ажилчныг хамруулав.  
C. 1956 онд Монголын Үндэсний Олимпын хороог байгуулав.  
D. 1952 оноос “Алдарт эх”-ийн I, II, зэргийн одонгоор шагнах болжээ.
13. 1924-1961 онд БНМАУ-ын боловсролын зорилго юу байсан бэ?  
A. Боловсролын системийг боловсронгуй болгож сургууль, амьдралын холбоог бэхжүүлэх  
B. Сургуулийн насны хүүхдийг бүрэн дунд боловсролтой болгох  
C. Сургалтыг үйлдвэрлэлтэй холбох үндсэн дээр сургуулийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх  
D. Орчин цагийн иргэний боловсролыг бүх нийтэд түгээх

14. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.




- .....
- A. Бага эмчийн болон сувилагчийн курсуудыг зохион байгуулсан. МУИС-ийг анхны 14 их эмч төгсөв.
- B. Өндөр настанд олгох улсын тэтгэврийн доод хэмжээг тогтоов. Алдарт эхийн одонгоор шагнах болов.
- C. Монгол улс Дэлхийн аваргад анхны алтан медалиа авав. Олимпын анхны медалиа авав.
- D. Тарваган тахал, халдварт өвчнийг эсэргүүцэх станц байгуулав. Улсын ариун цэврийг шалган байцаах албыг байгуулав.
15. Дэлхийн I дайн хэдээс хэдэн он хүртэл үргэлжилсэн бэ?  
 A. 1910-1914 он      B. 1914-1918 он      C. 1916-1920 он      D. 1918-1922 он
16. Дэлхийн II дайн хоёр том хүчинд хуваагдсан байв. Тэнхлэгийн улсуудад аль нь багтаж байсан бэ?  
 A. Их Британи      B. Франц      C. ЗХУ      D. Итали
17. Герман улс Дэлхийн I дайнд ямар зорилготой оролцсон бэ?  
 A. Балканд нөлөөгөө бэхжүүлэх, Сербийн зүгээс ирж буй улс төрийн сүрдүүлгийг устгах  
 B. Газар дундын тэнгисийн хоолойн бүс нутагт ноёрхогч байр сууриа хадгалах, Турк улсыг шахах  
 C. Шинэ колонийн эзэмшилтэй болох (гол төв Африк, Ойрхи дорнод, Хятадад нөлөөгөө өргөжүүлэх)  
 D. Дэлхийн тавцанд бүрэлдсэн хүчний харьцааг хадгалах, колонийг дахин хуваахгүй байх
18. Берлин, Ромын “Тэнхлэг”-ийн эх үүсвэрийг тавьсан улс төрийн түншлэлийн тухай Герман, Италийн хэлэлцээр хэзээ хийгдсэн бэ?  
 A. 1940 оны 9 сарын 27-нд      B. 1937 оны 11 сарын 6-нд  
 C. 1936 оны 11 сард      D. 1936 оны 10 сарын 25-нд
19. Завхан аймгийн Дөрвөлжин сумын малчин Б.Дорлиг Оросын Улаан армид 1942 онд 2500 төгрөг 137 адуу бэлэглэжээ. Энэ хүний нутаг Завхан аймгийг хэдийн тоогоор дугаарласан байна вэ?



- A.1    B. 2    C. 3    D. 4

20. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.



- A. Солонгосын дайн, Афганистаны дайн B. Вьетнамын дайн, Афганистаны дайн  
C. Солонгосын дайн, Вьетнамын дайн D. Дэлхийн II дайн, Төвөдийн бослого

21. 1937-1940 онд Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт гүнзгийрч, нийтийг хамрахад гол нөлөө үзүүлсэн улс аль вэ?

- A. ДИУ B. ЗХУ C. Япон улс D. Герман улс

22. 1930-аад онд 40 гаруй мянган монголчууд нутгаа орхин нүүжээ. Ийнхүү дүрвэх болсны шалтгаан юу вэ?

- A. Баруунтны алдаатай бодлого B. Зүүнтний алдаатай бодлого  
C. Дундад Иргэн Улсын суртал ухуулга D. Олон жил үргэлжилсэн ган зуд

23. 1932 оны зэвсэгт бослогын түүхэн сургамж юу вэ?

- A. Хууль эрх зүйн сул орчин зэвсэгт бослого гарах боломж олгодгийг сануулдаг  
B. Нийгэмд баян хоосны ялгааг гүнзгийрүүлж болохгүйг сануулдаг  
C. Чинээлэг аж ахуйтнууд зөвхөн хувийн эрх ашгаа эрхэмлэдгийг сануулдаг  
D. Төр засгийн алдаатай бодлогын улмаас зэвсэгт бослого гарч болохыг сануулдаг

24. 1930-аад онд Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршиг юу вэ?

- A. Япон улс шалтаг болгон Монголын хилд халдах болсон  
B. БНМАУ, ЗХУ-ын харилцаа муудсан  
C. ЗХУ эдийн засгийн тусламж үзүүлэхээ зогсоосон  
D. Олон хүн амь, эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирсон


25. 1989 оны 12-р сарын 10-ны өдөр Залуучуудын соёлын ордны талбайд болсон цуглаанаар улс төрийн ямар хүчин байгуулагдсаныг зарласан бэ?

- A. Шинэ үе бүлгэм B. Монголын Ардчилсан Нам  
C. Монголын Ардчилсан Холбоо D. Шинэ Дэвшилтэт Холбоо

26. 1990 оноос хойш Монгол улсын гадаад бодлогод гарсан гол өөрчлөлт юу вэ?

- A. Япон улстай харилцах харилцаандаа түлхүү анхаарах болсон  
B. Хятад, Оростой харилцах харилцааг хязгаарлах чиг шугам баримталсан  
C. АНУ-ын эрх ашгийг түлхүү анхаарах бодлого баримталсан  
D. Бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулах болсон

27. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.



- A. Өмч хувьчлалын эрхийн бичиг гаргав. Үнэт цаасны хороо байгуулав.  
B. Орон сууц хувьчлалын тухай хууль батлав. Иргэнд газар өмчлүүлэх хууль батлав.  
C. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр өмч хувьчлав. Өрхөд газар өмчлүүлэх хууль батлав.  
D. Үнэт цаасны хороо байгуулав. Орон сууц хувьчлалын тухай хууль батлав.